

Баримтат мэдээлэл



Монгол дах Шувуулахуй



Туг -Монгол улсын төрийн далбаа нь улаан, хөх, улаан хосолсон өнгөтэй байна. Далбааны гурав хуваасны нэгийн хэмжээтэй дундахь хэсэг нь мөнх тэнгэрийн **хөх**, түүний хоёр тал нь мандан бадрахын бэлгэдэл **улаан** өнгөтэй байна. Далбааны ишин талын улаан дэвсгэрийн төв хэсэгт Буддийн уламжлалт алтан соёмбо байрлуулна. Хөх өнгө бол мөнх тэнгэрийн орны бэлгэдэл юм. Түүнчилэн тэнгэр, ариуслын бэлгэдэл юм. Монгол орны уул толгодын орой дахь овоонд хүмүүс цэнхэр хадаг өргөсөн байхыг үзэж болно. Айлд ороход Монголчууд хүндтэй зочиндоо гүн хүндлэлийн бэлгэдэл болгон хадаг барьдаг.

Монголчууд шувуугаар ан хийж ирсэн уламжлалаас

Монголын анч шувуу сонирхогчдын холбооны дэд ерөнхийлөгч Д. Отгонсайхан

Ан агнуур бол балар эртний цагаас хүн төрөлхтөний амин чухал аж ахуй болж ирсэн юм. Балар эртний хүмүүс хоол хүнс, хувцас, бараг бүхий л хэрэгцээт зүйлсээ ан агуураас хангаж байлаа. Хүн төрөлхтөний өвөг дээдэс, махчин шувуудыг сурган ан ав хийлгэж ирсэн нь Ази тивээс гаралтай байх тухай түүхийн номноос уншиж болох билээ. Өргөн уудам тал, элсэн говь нь шувуугаар ан хийх урлагийг хөгжих чухам тохиромжтой орчин нутаг байсан гэж эрдэмтэд үзэж байдаг. Монголчууд эрт цагаасаа хүчирхэг эрэлхэг махчин шувуудыг сүлдээ болгон тахиж, тэднийг барьж тэжээн ан авд сургаж ахуй амьжиргаандаа хэрэглэж ирсэн ба шувуугаар ан хийлгэх урлаг төв Ази, Монгол орноос гаралтай гэж дүгнэх ихээхэн боломжтой юм. Жирийн монголчууд хоол хүнснийхээ дийлэнхийг ан аваас олж “эрчүүд нь дайн тулаан хийж, шонхор шувуугаар ан агнан сэтгэл амар байцгаана” хэмээн эрдэмтэн аялагчид бичиж үлдээснийг үзэж болно. Судлаачид махчин шувууг сурган анд ашиглах урлагийг “шувуулахуй” хэмээнэ гээд монголчууд бол шувууг сургаж анд ашиглах ихээхэн цогц мэдлэгийг эзэмшсэн хүмүүс юм гэж үзсээр ирсэн. Эртний монголчууд ан авд бүргэд, шонхор харцага зэргийг ашиглаж байв. Бүргэдээр чоно, үнэг, хярс, туулай зэрэг амьтдыг, харин шонхор харцагаар галуу, нугас, ятуу болон бусад шувуудыг бариулдаг байжээ.

Дундад зууны үед Туркэд “акшонкур”, Монголд “шонхор”, “хай-чин” буюу “хай-гун-чин” гэж нэрлэх том шонхорын зүйлүүд буюу цагаан шонхор (*Falco rusticolus*), эгэл шонхор (*Falco peregrinus*), идлэг шонхор (*Falco cherrug*) зэрэг хурдтай том биетэй шонхорын зүйлүүдээр ан хийлгэж тогоруу, нугас, галуу тэргүүтэнг бариулдаг байжээ.

Цагаан шонхор бол эртний Монголчуудын алтан ургийн буюу Хиад боржигон овгийн шүтээн сүлд байсан ба Чингис хааны дээд өвөг Буданчарын тухай түүхэнд ч энэ тухай өгүүлсэн байдаг.

Монголын нууц товчооны 63-р бүлэгт”...Есүхэй баатар Тэмүүжин хүүгийн хамтаар явтал Хонгирад овгийн Дай сэцэнтэй дайралдахад Дай сэцэн өгүүлрүүн: “Есүхэй худаа! Цагаан шонхор шувуу нар сарыг атгаж ирээд миний гар дээр буулаа гэж урд шөнө би сайхан зүүд зүүдэллээ. Нар сарыг бид нүдээрээ хардаг билээ. Гэтэл нар сарыг атгасан цагаан шонхор ирж гар дээр минь буулаа гэж зүүдэлсэн минь юутай сайхан. Би хүмүүст зүүдээ ярьж өглөө. Гэтэл Есүхэй худ та хүүтэйгээ морилж ирэх учиртай байж. Хиад боржигон овгийн сүлд тань миний зүүдэнд ирсэн байж” гэсэн байдаг.

Хаад ноёд сайн шонхор шувууг голчлон Байгаль нуур, Манжуур, Алс дорнод, Солонгос, Бохайгаас барьж ирүүлдэг байв. Цагаан шонхор шувуу Монгол нутгийн унаган шувуу болох нь эргэлзээгүй юм. Италийн жуулчин Марко Поло “Ертөнцийн сонин хачин” номынхоо 74-р зүйлд “4 хоногийн аялал хийвэл Хойд тэнгист хүрмөй. Тэндэхийн олон арлууд дээр цагаан шонхор ихээр байх ба Хаан тэдгээр шувуудаас хүссэнээрээ барьж авчирна” гэжээ. “Лувсанданзангийн Алтан түүх”-д Чингис хааны ууган хүү Зүчийн байлдан дагуулсан Уйгур Хиргис ноёд Чингис хаанд шонхор харцага хүргүүлэг байсан тухай бичсэн байна.

Хүн Дунху зэрэг нүүдэлчин овгоос хөрш зэргэлдээ овог улсад шонхор шувууг бэлэг болгон өгч байжээ. Монголчууд ч байлдан дагуулсан овог улс орноосоо шонхор шувууг татвар болгон авч байсан байдаг. Монголын нууц товчооны 29-р зүйлд “Тэд Бодончарыг харцага шувуугаа өг гэхэд тэрээр өгсөнгүй” 239-р зүйлд Туулай /1207/ жил Зүчи ойн ардыг дайлаар мордоход Буха газарч хийж явсан бөгөөд Зүчийн цэрэг Түмэн ойрадын нутгаар гарч Шишгэд голыг хүрэхэд хиргис, ойрад ноёд Чингис хаанд өргөх цагаан шонхор, цагаан морьд, хар сэлэм зэрэг бэлэг барин угтан ирвээ “ гэжээ. 918-1392 оны хооронд оршиж байсан Корё улс их хаанд олон тооны шон кой мэ буюу шонхороор татвар өгч байв.

Их Монгол улсын үед Оросоос татварыг шонхороор төлж болдог байсан бөгөөд Оросоос Монголын эзэнт гүрэнд олон тооны шонхор ирдэг байжээ. Оросын алдарт жуулчин Афанасий Никитин Энэтхэгийн тухай номондоо “Оросын хаанаас илгээсэн цагаан шонхор аясан тэрэгнүүд татарын элч Ширваншин Асанбэкийг 2 долоо хоног хүлээн зогссон ба тэрэгнүүдэд 90 цагаан шонхор ачсан байлаа” гэжээ. Түүнчилэн 1491 онд Оросын 3-р Иван хаан алба татварт цагаан шонхор оруулж тооцох талаар Алтан ордны хаан Мэнлигтэйтэй гэрээ хийж байсан байна. Шонхорыг алба гувчуурт авч байсан тухай сүүлчийн баримт нь 1491 онд Монголын Их хаанд өргөх бэлэгт Оросоос 6-н тооны хамгийн сайн цагаан шонхор оруулсан тухай байна.

Монголчууд бүргэд, харцагыг ч анд ашиглаж байсан. Гурван голын овог аймгуудын толгойлогчдын нэг Бодончар мунхаг ах дүү нартаа хөөгдөөд Онон мөрний Балжин аралд өвсөн овоохой барьж сууж байхдаа хар морьныхоо дэл сүүлээр урхи хийж барьж авсан саарал харцага шувууг сурган хар хур шувуу бариулж байсан тухай Монголын нууц товчоонд байдаг.

Италийн жуулчин Марко Поло “Ертөнцийн сонин хачин” номынхоо 92-р зүйлд “...Их хаанд чоно, үнэг, зээр, буга бариулдаг олон тооны бүргэд байдаг. Тэдгээр нь олон тооны ан барих бөлгөө. Чоно барьдаг хамгийн том хүчирхэг бүргэд байдаг. Тэдний махир хошуунаас зайлж чадах чоно нэгээхэн ч үгүй бөлгөө” гэжээ.

Их Монгол гүрний үеэс шувуугаар ан ав хийлгэх нь амьжиргааны хэв маяг байхаа больж их хаад ноёдын зугаа цэнгэлийн ажил болж хувирсан байдаг . Их Чингис хаан шувуудаар ан хийх талаар онцгой сайн мэдлэгтэй байсан бөгөөд ан авыг төрийн ажилтай зэрэгцүүлэн өндөр төвшинд авч үзсэн байдаг. Хааны үед ан авыг, түүний дотор шувуудаар хийх ан авыг цэрэг дайны сургалттай холбон үзэж байсан бөгөөд байлдааны тугандаа цагаан шонхорыг сүлд болгон тахисан байлаа. Чингис хааныг таалал болсоноос хойш эзэнт гүрэн нь тарж бутарсан цагаас хойш ч шувуудаар ан ав хийлгэх ажил урт удаан хугацааны туршид хадгалагдаж уламжилж ирсэн байдаг.

Чингис хааны ач хүү, Монголын Юань гүрний их хаан Хубилай шувуугаар хийх ан авыг цаашид уламжлан оюун санааны алжаалаа тайлах нэг ёсны зугаа амралт болгон хөгжүүлж байв. Чингис хааны ач хүү Монголын их Юань гүрний эзэн Хубилай хаан амралт, цэнгэлийн байдлаар шувуугаар ан ав хийх урлагийг уламжлан үргэлжлүүлж байсан юм.

“Хубилай хаан 10 мянган шувуучин, 5 мянга гаруй шонхор шувуу, бүргэдээ аван ан хийдэг. Гол мөрний эргээр явж бүргэдээр усны шувууд бариулдаг байлаа. Хаан нэг газар хэт олон хүн, шувууг бөөгнүүлдэггүй байсан. Ан авын олз омог ихтэй байхын тулд шувуучдаа олон газар тараан байрлуулдаг байсан. Хаан ойр дотны ноёдоо дагуулан хамгийн сайн 20 шонхороо шадарлуулан дагуулдаг байлаа. Хаан олон ноёд, баатрууд, ачаа ачсан заануудаа дагуулан гэртээ морилдог байсан. Шувуучид нь хаандаа сүрэг тогоруу явж байна гэж хэлэхэд хаан нэг шувуугаа тавьдаг. Тэгэхэд тавьсан бүргэд эсвэл шонхор нь заавал нэг тогоруу барьдаг байсан. Үүнд хаан ихэд баясан цэнгэдэг байсан.” гэж Марко Поло “Ертөнцийн сонин хачин” номондоо тэмдэглэсэн байдаг.

Монголчууд шувуу сурган ан хийж байсан нь (Дамдинсүрэнгийн Шижирмаа)

Эрт цагаас Монголчууд харцага, шонхор, бүргэд зэрэг махчин шувуудыг сургаж ан ав хийдэг байсан. Эртний монголын овог аймгууд шонхор шувууны хүч, чадал, хурц дайчин, хурдан шалмаг, эрэлхэг зоригийг хүндлэн сүлдээ болгон тахиж байжээ. Хүн гүрний эзэн хаан Атиллагийн үед цэргүүдийн бамбайн дээр шонхор шувууг дүрсэлдэг байжээ.

Чингис хаан бол хиад, боржигон овгийн хүн. Энэ овог нь Монголын язгууртан дээдсийн алтан ураг хэмээгддэг бөгөөд Чингис хааныг оролцуулан алтан ургийнхан Монголын төрийг 350 гаруй жилийн турш барьж байсан байна. Хиад, боржигон овгийн шүтээн нь цагаан шонхор шувуу байсан.

Монголчуудын байлдан дагуулж, засан товхиуулсан дэлхийн талыг эзэлсэн их гүрний нутаг бүрд цагаан шонхортой сүлд намирч байсан нь нь дамжиггүй. Сүхбаатар аймгийн нутгаас олдсон 13 дугаар зууны үеийн Монгол язгууртны булшнаас гарсан бүсний толин дээр цагаан шонхор шувууг дүрсэлсэн байсан.

Монголын нууц товчоонд Чингис хаан 6 сайдынхаа нэг, дотно анд Боорчи магтан дуулахдаа шонхор шувуу мэт дайчин шийдвэртэй гэсэн байдаг.

Чингис хаан, түүний хүү Өгөөдэй, Цагаадай нар шувуудыг сургаж ан авдаа ашигладаг байсан бөгөөд гадаад орнуудаас шонхор шувууг бэлгэнд авдаг байсан байна. Оросын цагаан хаанаас 1675 онд Монголын Богд ламд цагаан шонхор шувууг бэлэг болгон ирүүлсэн тухай тэмдэглэгдсэн байдаг.

Монголын Юань гүрний үед шувуугаар ан ав хийх нь маш их түгээмэл болсон ба Хубилай хааны дэргэд 10 мянган шувууч байсан гэдэг.

Харамсалтай нь нэг шувууч хичнээн шонхор сургадаг байсан тухай мэдээ үлдээгүй байна. Махчин шувуудыг сургаад эзнийх нь нэртэй мөнгөн бөгжөөр бөгжилдөг байж. Ийм учраас шувууг бөгжилдөг нь Монголоос гаралтай гэж үздэг.

Өнгөрсөн жилийн 12 дугаар сард Улаанбаатар хотын төвд баруун мөрөн дээр нь шонхор шувуу суулгасан Марко Пологийн хөшөө боссон. Марко Поло нь Чингис хааны ач хүү Юан улсын их хаан Хубилайн ордонд 17 жил амьдарч их хааны зараалаар олон удаа дипломат болон захиргааны үүрэг гүйцэтгэж явсан хүн юм. (127-1292). Марко Поло бол Монголчуудын соёл уламжлал, үнэт зүйлсийг барууны ертөнцөд анх удаа танилцуулсан түүхч хүн байсан гэж Монголчууд үздэг. Марко Поло “Ертөнцийн сонин хачин” хэмээх номондоо их хаан жил болгон хойд далай руу цагаан шонхор бариулахаар элч нараа явуулдаг байж. Далайн дундах нэгэн арал дээр цагаан шонхор олноор байх бөгөөд хаан тэдгээрээс хүссэнээрээ бариулж авчруулдаг байсан гэж бичсэн байдаг.

Монголын өнөөдрийн шувуулахуй

Бүргэдийн ав бол хүн амьтан хоёрын хоорондох гайхамшигтай харилцааны нэг бөгөд одоогоор Монгол улсын Баян-Өлгий аймагт энэ уламжлал хадгалагдсаар байна.

Махчин шувуудаар ан ав хийх уламжлал Төв Азиас гаралтай бөгөөд казах эрчүүд хамгийн том хүчирхэг махчин шувуу болох бүргэдийг сурган морин дэл дээрээс ан хийсээр байна. Үнэг, туулай, чоныг ч авлаж арьс үсийг нь ашигладаг ба бүргэдийн анчид цаст уул талдаа өнөөдөр ч ан аваа хийсээр байна.

Баруун Монгол бол маш хүйтэн нутаг. Өдрийн агаарын температур жилийн дунджаар өдөр нь 0 градус орчим, ихэнхдээ 0-ээс доош градус байдаг. Өвлийн цагт туулай, үнэг, чонын арьс нь гүйцэж хамгийн сайхан болдог үе бөгөөд казах анчид бүргэдтэйгээ өвөл ан хийдэг.

Бүргэдийн ан бол эртний спорт. Энэ нь хүн, байгаль амьтантай эртнээс өнөөгийн түүх хүртэл хэрхэн хамт явж ирснийг бидэнд сануулах биз. Дэлхийн олон оронд мартагдаж тасарсан энэ уламжлал өнөөгийн казах ард түмэнд өргөн дэлгэрч байгаа нь энэ уламжлалаа мартаж гээсэн бусад улс үндэстэнд эргэн дэлгэрлийг авчрах дамжиггүй.